

## Ард Менежмент ҮЦК ХХК

### 2019 оны онцлох үйл явдал

- Монгол Улсын хамгийн анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Санг үүсгэн байгуулсан.
- Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг Жинст Увс ХК-тай нэгтгэх замаар компанийн хэлбэрийг өөрчлөн Монголын Хөрөнгийн Биржид амжилттай бүртгүүлэв.
- Ард Кредит ББСБ-ыг нээлттэй хувьцаат компани болж, Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлэх ажлыг бусад мэргэжлийн оролцогчидтой хамтран амжилттай гүйцэтгэв.
- Ард Холдингс Интернэшнл ХХК-г үүсгэн байгуулахтай холбоотой үүсгэн байгуулах, хөрөнгө оруулалт хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн.

### Үйл ажиллагааны тайлан

2019 он Ард Менежмент компанийн хувьд төдийгүй Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хувьд онцлог жил байлаа. Учир нь Ард Менежмент нь Үндэсний Хувьчлалын Санг үүсгэн байгуулснаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлд зайлшгүй шаардлагатай байсан хамтын хөрөнгө оруулалтын санг бий болгох эхлэлийг тавилаа. Уг сан нь Монгол Улсын эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг төрийн оролцоотой компаниудын хувьчлалд оролцох, түүний бүтээж буй баялгаас хөрөнгө оруулагчиддаа хувь хүртээх зорилготой болно. Үндэсний Хувьчлалын Сан нь 2020 онд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байгаа бөгөөд үйл ажиллагаа эхлүүлснээр хөрөнгийн зах зээлд үлэмж хэмжээний үнэт цаасны арилжааны идэвхийг бий болгоно гэж найдаж байна. Мөн Ард Менежмент нь толгой компани болох Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний хөрөнгө оруулалттай компаниудын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр нэлээдгүй ажил гүйцэтгэн, 2019 оныг амжилттай үдлээ.

2019 онд Ард Менежментийн нийт хөрөнгө 378 сая төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд Үндэсний Хувьчлалын Санд хийсэн хөрөнгө оруулалт голлон нөлөөлсөн байна. Мөн Ард Менежмент нь 252 сая төгрөгийн орлоготой, нийт дэлгэрэнгүй ашиг 31 сая төгрөгт хүрсэн байна. Тайлант онд Ард Менежмент нь бүтэц, зохион байгуулалтаа өөрчилж, үндсэн үйл ажиллагаандаа төвлөрч ажилласан нь үндсэн бус үйл ажиллагааны орлого болон компанийн хүний нөөцийн зардлыг бууруулахад нөлөөлсөн байна.

Голлох үзүүлэлтүүд (сая төгрөг)

